

ХЯТАДЫН НИЙГМИЙН ШУА-ИЙН АЗИ-НОМХОН ДАЛАЙН ХҮРЭЭЛЭН (Товч танилцуулга)

1988 онд байгуулагдсан Ази-Номхон далайн хүрээлэн бол Хятадын Нийгмийн ШУА-ийн харъяа судалгааны байгууллага бөгөөд Хятаддаа Ази-Номхон далайн асуудлыг тусгайлан судалдаг хамгийн том хүрээлэн юм. Тус хүрээлэнгийн судалгааны хүрээ нэн өргөн бөгөөд Ази Номхон далайн бүс нутгийн (АНДБН) улс төр, эдийн засаг, гадаад харилцаа, нийгмийн соёл, шашин, сэтгэлгээ зэрэг бүхий л салбарыг хамардаг. Энэ хүрээлэнгийнхэн гадаадын болон дотоодынхоо ижил төрлийн судалгааны байгууллагуудтай өргөн харилцаатай хамтран ажилладаг юм.

Ирж буй XXI зууныг "Ази-Номхон далайн зуун" болно гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрч буй одоо үед тус хүрээлэн Ази-Номхон далайн бүс нутгийн ард түмнүүд харилцан ойлголцох, Хятад болон бүс нутгийн улс орнуудын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг ахиулахад идэвхтэй үүрэг гүйцэтгэж байна.

Бүтэц, зохион байгуулалтын хувьд уг хүрээлэн 4 тасаг, 1 төв, хэвлэлийн болон захиргааны хэлтэстэй.

1. Улс төр, эдийн засгийн судалгааны тасаг нь:
 - а. АНДБН-ийн эдийн засгийн хөгжил, эдийн засгийн бодлого;
 - б. АНДБН-ийн улс төрийн байдал, улс төрийн байгуулал, улс төрийн байгууллага;
 - в. Бүс нутгийн улсуудын улс төр, эдийн засгийн харьцуулсан судалгааг эрхэлдэг.

Мөн Зүүн хойт Ази, Өмнөд Азийн асуудал, АСЕАН, (Зүүн өмнөд Азийн

улсуудын холбоо) зэрэг өргөн хүрээтэй сэдвээр судалгаа хийдэг.

2. Олон улсын харилцаа ба хамтын ажиллагааны тасаг нь:

а. АНДБН-ийн интеграц ба хамтын ажиллагааны байгууллага, тэдгээрийн бүтэц, үйл ажиллагаа

б. АНДБН-ийн улс хоорондын харилцаа хийгээд бүс нутгийн аюулгүй байдал:

в. Хятадын гадаадад нээлттэй байх бодлого ба хөрш хил залгаа улсуудын харилцааг судалдаг. Ялангуяа бүс нутгийн интеграц, АНДБН-ийн улс орнуудын харилцаа хийгээд Зүүн Азийн эдийн засгийн хөгжил зэрэг олон талын судалгаанд анхаарлаа чиглүүлдэг.

3. Нийгэм, соёлын судалгааны тасаг нь:

а. АНДБН-ийн соёлын өв, үүсэл хөгжил

б. уламжлалт соёлын орчин үеийн нийгэмд гүйцэтгэх үүрэг.

в. улс үндэстнүүдийн соёлын харьцуулсан судалгаа

г. АНДБН-ийн нийгмийн хөгжил, бүтэц, нийгмийн асуудал зэргийг судална.

4. Шашин, гүн ухааны тасаг нь: АНДБН-ийн шашин, гүн ухааны асуудлыг голлон судалдаг бөгөөд судалгааны гол хүрээ нь Энэтхэгийн гүн ухаан, санскрит эх бичиг судлал, буддын гүн ухаан зэрэг болно. Орчин үеийн дорно дахины шашин гүн ухаан, шашин хийгээд нийгэм эдийн засгийн харилцааг ч гүнзгийрүүлэн судалдаг байна.

5. Хэвлэлийн хэлтэс нь 2 долоо хоног тутмын "Өнөөгийн Ази", улирлын "Өмнөд Азийн судалгаа" зэрэг сэтгүүл болон дотоод хэрэгцээнд зориулан "Ази-Номхон далайн (холбогдолтой) материал"-ыг хэвлэн, тараадаг. Мөн дээрхи хэвлэлүүдээс түүвэрлэн англи хэлээр хэвлэн гадаадад тараадаг байна.

6. Мэдээлэл, сургалтын төв нь Ази-Номхон далайн холбогдолтой баримт, мэдээллийг цуглуулан эмхэтгэж, судалгааны болон засаг төрийн байгууллага, үйлдвэр аж ахуйн газар, пүүс компани зэрэгт мэдээллээр үйлчилж, дотоод гадаадын байгууллагад зуучлах, харилцаа холбоо тогтооход нь туслах, сургалт зохион байгуулах, мэдээллийн сүлжээг бий болгох зэрэг ажлуудыг эрхэлнэ.

Тус хүрээлэн нь судалгааны ажлаас гадна эрдэм шинжилгээний ярилцлага, бага хурал, олон улсын эрдэм шинжилгээний олон тооны хурал зохион байгуулдаг. Хүрээлэнгийн судалгааны сэдвээс дурдвал "АНДБН-ийн интеграцийн хөгжил ба Хятадын бодлого", "90-ээд оны АНДБН-ийн улс төр, эдийн засгийн байдал", "Япон эдийн засгийн их гүрнээс улс төрийн их гүрэн болж буй нь", "Солонгосын хойг ба Зүүн хойт Азийн аюулгүй байдал", "Шилжилтийн үеийн Энэтхэгийн эдийн засаг", "Тайландын эдийн засгийн үсрэлт", "Өнөөгийн дорно дахины гүн ухаан", "Өнөөгийн Ази-номхон далайн шашин", "Хятад-Энэтхэгийн эдийн засгийн харьцуулсан судалгаа" гэх мэтээр олон сэдэв байна. Тус хүрээлэн бие дааж болон бусад байгууллагатай хамтран "Дэлхийн шинэ байдалд буй Зүүн Ази ба Европ", "Хүйтэн дайны дараах Азийн аюулгүй байдал", "Хятад БНСУ-ын харилцаа", "Хятад-энэтхэгийн харилцаа" гэх мэт сэдвээр эрдэм шинжилгээний хурал байнга зохион байгуулдаг юм.

Ази-Номхон далайн хүрээлэн нь "Хятадын нийгмийн ШУА-ийн өмнөд Азийн соёлын солилцооны төв", "Австрали ба өмнөд Номхон далайн судлалын төв", "Өмнөд Солонгос судлалын төв", "Ази Номхон далайн мэдээлэл сургалтын төв" зэргийг хамааран удирдахын зэрэгцээ эдгээр төвд магистр, докторын зэрэгтэй эрдэмтдийг бэлтгэн гаргадаг.

Хүрээлэнгийн гадаад харилцаа жилээс жилд өргөжиж, жил бүр олон тооны эрдэм шинжилгээний ажилтныг гадаадад судалгааны ажил хийлгэх, буюу мэргэжил дээшлүүлэхээр явуулдаг байна. Мөн АНДБН-ийн олон орноос жил бүр судлаач мэргэжилтнүүдийг хүлээн авдаг.

XXI зуун буюу "Ази Номхон далайн эрин үе" ойртох тутам тус

хүрээлэнгийн дотоод, гадаад харилцаа хамтын ажиллагааны Цар хүрээ өргөжин тэлж, АНДБН-ийн асуудлыг улс үндэстэй, шинжлэн судлах ажлыг улам эрчимтэй хийж байна.

Л.Бэгзжав